

# МОНГОЛ ЗАЛУУЧУУДЫН НИЙГМИЙН ОРОЛЦООНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Ш. Оюунцэцэг  
Докторант, ахлах багш  
Удирдлагын академи

oyuntsetseg.sh@naog.gov.mn

**Abstract:** The paper aims to shed light on a topic that is considered not only an important factor for the development of countries but its young adults' development; that is "young adult participation" in society. Based on theories, methodology, and literature reviews researcher attempted to study 15-34 age cohort's social participation. Moreover, as a unique take the researched studied young adult's participation at an organizational level support and development. Lastly, in discussion section, future considerations and recommendations are included.

**Түлхүүр үг:** сайн дурын ажиллагаа, санаачлага, оролцооны загвар, залуучуудын нийгмийн оролцооны гурвалжин, Kurt De Backer ба Marc Jans нарын загвар, Hart-ийн загвар, Shier-ийн оролцооны зам

## УДИРТГАЛ

Дэлхий дахинд залуучуудыг улс орны хөгжлийг тодорхойлогч, эх орны ирээдүйн эзэд хэмээн хүлээн зөвшөөрч, тэдний асуудалд анхаарлаа хандуулж, тэдний өмнө тулгардаг асуудлуудыг шийдвэрлэхэд өөрсдийнх нь оролцоог хангах, хөгжих боломж олгоход чиглэсэн төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2014 онд 198 улс орныг хамруулсан судалгаанд 122 улс залуучуудад чиглэсэн бодлого, хөтөлбөртэй байдаг гэжээ (The state of youth policy in 2014). Дэлхийн даяарчлалтай холбоотойгоор хөгжлийн шинэ нөхцөл байдал бий болж, залуучуудын санаа бодлыг сонсох, шийдвэр гаргахад тэдний дуу хоолой, идэвх санаачилга, оролцоог нэмэгдүүлэх шаардлага тулгарсан. Ийнхүү залуучуудын нийгмийн амьдралд оролцоо оролцоог нэмэгдүүлж, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах идэвхтэй иргэн болгон төлөвшүүлэх бодлогыг дэлхий нийтээр баримтлах болсон байна.

Монгол улсад залуучууд улс орныхоо хөгжилд гар бие оролцох, нийгэмд эзлэх байр сууриа бий болгоход тэдний нийгмийн харилцаан дахь оролцоо үүргийг нэмэгдүүлэх явдал чухал байна. 2011 онд залуучуудын нийгмийн оролцоо ямар байгааг судалсан судалгаанд “залуучуудын оролцоо маш чухал”, “залуучууд улсаа авч явна” гэх үзэлтэй залуучууд нийт судалгаанд оролцогчдын 86.3 хувийг эзэлсэн гэсэн үр дүн гаргажээ (XXI зуун-Монголын залуучууд суурь судалгаа, 2011). Эндээс харахад

залуучууд улс орныхоо хөгжилд гар бие оролцох, шийдвэр гаргах түвшинд оролцох хүсэлтэй болохыг харуулж байна.

## ОНОЛ АРГА ЗҮЙ

Монгол улсын хүн амын дотор хамгийн том бүлгийг бүрдүүлэгч нь 15-24, 25-34 насны бүлэглэл бөгөөд нийт хүн амын 34.9 хувийг (1 сая 68 мянга) эзлэж, хөдөлмөрийн насны хүн амын үлэмж хэсгийг бүрдүүлж байна (ҮСХ, 2018). Эдгээр залуучуудын 155 мянга нь их, дээд сургууль, коллежид суралцдаг оюутнууд байгаа нь бараг зургаан залуучууд тутмын нэг нь оюутан болж байна (<https://www.1212.mn>). Олон улсын их дээд сургуулийн практикаас харахад оюутнуудын нийгмийн оролцоог чухалчлан авч үздэг ба нийгэм болоод хүмүүсийн сайн сайхны төлөө гэсэн сэтгэл, итгэлтэй байх нь тэдний төлөвшлийн зайлшгүй нэг чадамж гэж үздэг.

15-34 насны эрэгтэйчүүдийн 50 орчим, эмэгтэйчүүдийн 38 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр эрхлэлтийн байдал байршлаас шалтгаалан нилээд ялгаатай байна. Тухайлбал, хотын залуучуудын 39.2 хувь нь ажил эрхэлж байгаа бол хөдөөд энэ үзүүлэлт ердөө 22.2 хувьтай байна. Албан бусаар хөдөлмөр эрхэлж буй нийт хүмүүсийн 30 хувийг залуучууд эзэлж байна (Монгол улсын хүний хөгжлийн илтгэл, 2016). Гэвч залуучуудын эзэмшсэн ажил, мэргэжлийн ур чадвар нь хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцэхгүй байна. Ажил хайж байгаа залуучуудын ур чадварын төрөл, түвшинд ажил олгогчид сэтгэл дундуур байгаа талаар 2008 онд хийсэн ОУХБ-ын “Сургуулиас ажилд шилжигчдын судалгаа”-нд тэмдэглэжээ.

Монгол улс залуу хүн бүрийг улс орны хөгжлийн асар их нөөц, ирээдүй, идэвхтэй түншлэгч гэж харан, улс орны хөгжилд залуучуудын хүчийг бүрэн ашиглах, залуучуудын санал санаачилгад тулгуурлан тэдний бодит хэрэгцээг хангахын төлөө төр анхаарч, тэдэнд дэмжлэг үзүүлэх шаардлага тулгарч байна. Залуучуудын нийгмийн оролцоо нь залуучуудын эрх мэдэл, амьдралын ухааныг дээшлүүлэх, иргэний үүргээ биелүүлэх, хөдөлмөр эрхлэх боломж, боловсролын үр шимийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэртэй. Монгол улсын хүний хөгжлийн илтгэлд “Залуучууд ерөнхийдөө улс төрийн тогтолцоонд идэвхгүй байр суурь баримталдаг, сэтгэл дундуур байдаг хэдий ч иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, спорт, урлаг соёл, байгаль орчин зэрэг нийгмийн амьдралын олон салбарт идэвхтэй оролцдог. Харин залуучууд жагсаал цуглаан, эсэргүүцэл хийх зэрэг албан бус, тодорхой зорилготой улс төрийн үйл ажиллагаанд илүү оролцох хандлагатай байдаг” гэжээ (Монгол улсын хүний хөгжлийн илтгэл, 2016). Монгол залуучуудын сурч боловсрох, эрүүл мэндийн

үйлчилгээ авах, ажил хөдөлмөр эрхлэхэд нь олон асуудал тулгарсаар байгаа тул залуучуудын хөгжил, оролцоог дэмжих зорилгоор 2017 оны тавдугаар сард УИХ-ын нэгдсэн чуулганаар “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай” хуулийг баталж, энэхүү хуулийг 2018 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн байна.

“Залуучуудын нийгмийн оролцоо гэдэг нь залуучууд бодит хэрэгцээгээ хангахаар нэгэн зорилгын дор нэгдэж, өөрсдийгөө сорьсон, дан ганц өөрсдийн сайн сайхны төлөө бус бусдад ч бас эерэг нөлөөлөл үзүүлэхээр хамтран нэгдэж ажиллахыг хэлнэ” хэмээн АНУ-ын Үндэсний Залуучуудын Холбоо (1975)-ноос тодорхойлжээ. Канад улсын Сэтгэцийн Эрүүл Мэндийн Холбоо (1995)-ноос “Залуучууд өөрсдийн хүч нөлөө, сонирхлыг олж илрүүлэх, бодит боломж дээр тулгуурлан өөрсдийн авъяас мэдлэгээр дамжуулан шийдвэр гаргах процесст оролцон, хувь хүн төдийгүй нийгмийн хөгжилд нөлөөлөхийг залуучуудын нийгмийн оролцоо гэж ойлгож болно” гэжээ. Залуучууд инноваци, бүтээлч санаачилга, шинэ санаа гаргах замаар нийгмийн хөгжилд тус нэмэр хүргэх асар их нөөцтэй юм.

Залуучуудын нийгмийн оролцооны загваруудыг авч үзье.

*Kurt De Backer ба Marc Jans нарын загвар:*

Энэхүү загварт “Залуучуудын нийгмийн оролцооны гурвалжин” гэсэн ойлголтыг тайлбарлахдаа залуучууд гурван тодорхой нөхцөл бүрдсэн тохиолдолд л нийгэмд идэвхтэй оролцдог гэсэн байна (Kurt & Jans, 2002).

Үүнд :

1. Залуучуудыг сорих асуудал буюу сорилт байх хэрэгтэй.
2. Залуучууд энэхүү сорилтыг давах, өөрчлөлтийг хийж чадна гэсэн мэдрэмж, итгэл үнэмшил, чадвар байх хэрэгтэй.
3. Тухайн асуудлыг үр ашигтайгаар шийдэхүйц нэг зорилготойгоор нэгдсэн, нэгдмэл болсон байх хэрэгтэй.

*Hart-ийн загвар:*

АНУ-ын нийгэм судлаач Hart 1992 онд гаргасан судалгаандаа залуучууд нийгэмд өөрсдийн дуу хоолойг хүргэж, шийдвэр гаргах процесст оролцох боломжтой болохыг нийгмийн оролцооны шат буюу найман алхамаар тодорхойлсон (Children's Participation: From Tokenism to Citizenship, 1992). Эхлээд дунд болон ахмад үеийхэн нь ямар нэгэн төслийг зохион байгуулж, түүнд залуучуудыг сайн дурын байдлаар татан оролцуулна. Дараагийн алхамд тухайн залуучууд өөрийн санал бодлоо хуваалцаж, шийдвэр гаргахад өөрсдийн бодлыг илэрхийлнэ (энэ үед ахмадуудаас зөвлөгөө өгөх хариу үйлдэл ирдэг). Түүний дараа залуучууд үйл ажиллагаанд оролцохдоо эрх мэдлийг хуваалцан, зохион байгуулалтанд орж эхлэдэг. Ингээд туршлагатай болсон залуучууд өөрсдийн санаачилгаар, өөрсдийн эрх мэдлийн хүрээнд төслийг удирдаж,

хэрэгжүүлж эхэлдэг. Хамгийн сүүлийн алхамд залуучууд өөрсдөө санаачлаад, удирдан зохион байгуулж, төслийг хэрэгжүүлэхдээ ахмадуудаа урьж оролцуулан шийдвэрийг хамтдаа гаргадаг.

*Shier-ийн оролцооны зам:*

Залуучуудын оролцоо нь нэг удаа болох арга хэмжээ биш процесс юм. Байгууллага залуучуудын оролцоог дэмжихэд хэр бэлэн байгааг багц асуултанд хариу авсанаар тодорхойлж болно (Shier, 2001). Байгууллагаас асуух багц асуултын эхэнд удирдлагаас залуучуудын оролцоог дэмждэг эсэхийг, байгууллага залуучуудын оролцоог дэмжих зохион байгуулалт, нөхцөл боломжийг бий болгосон эсэхийг, байгууллагын бодлого хөтөлбөр, дотоод дүрэм журамд залуучуудын оролцоог дэмжих талаар тусгасан эсэхийг асуудаг. Энэхүү багц асуулт нь тухайн байгууллага залуучуудыг аливаа үйл ажиллагаанд татан оролцуулахад хэр бэлэн байна вэ?; Хаана сайжруулалтыг хийх хэрэгтэй байгаа вэ?; Хэрхэн үр дүнтэй зохион байгуулах вэ? гэсэн асуултуудад хариулт олоход нь тусладаг. Shier-ийн оролцооны зам нь:

1. Залуучуудыг сонсоно.
2. Залуучууд өөрсдийн үзэл бодлыг илэрхийлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.
3. Залуучууд үзэл бодол, санаачилгаа хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.
4. Залуучуудыг шийдвэр гаргах процессд оролцуулна.
5. Залуучуудтай шийдвэр гаргах, эрх мэдэл болон хариуцлагыг хамтран хүлээнэ.

Залуучууд нийгмийн үйл ажиллагаанд албан болон албан бус бүтцээр дамжуулан хувиараа, хамтдаа гэх зэрэг янз бүрийн түвшинд оролцдог. Залуучуудын нийгмийн оролцоог дараах байдлаар тодорхойлж болох юм. Үүнд:

- *Төрийн Бус Байгууллагуудад залуучуудын оролцоо* - Монголд 12 мянган ТББ бүртгэгдсэн бөгөөд тэдний хагас нь л идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.
- *Залуучуудын санаачилга, сайн дурын ажиллагаа* - Нутаг орноо хөгжүүлэх, нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдэх арга замыг хайх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зэрэгт залуучууд хүчээ нэгтгэж, хувь нэмрээ оруулж байгаа олон жишээг дурдаж болно.
- *Залуучуудад чиглэсэн хөтөлбөрүүд, үйл ажиллагаан дахь оролцоо* - Залуучуудын олон байгууллагууд залуучуудын бүтээлч сэтгэлгээ, манлайллын ур чадвар, амьдрах ухааныг хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв өнгөрүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх анхаардаг.

Монголд одоогоор залуучуудын сайн дурын ажиллагааг шинэлэг хэлбэрээр хөхүүлэн дэмжих дэд бүтэц бүрэн хөгжөөгүй байна. Сайн дурын ажиллагаа нь ядуурлыг бууруулах, нийгмийн нэгдмэл байдлыг хангах, залуучуудыг эрх мэдэлжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд иргэн төвтэй стратегийн хэрэгсэл юм гэж Монгол улсын хүний хөгжлийн илтгэл (2016)-д дурьдсан байна.

Улс орны хөгжлийн үйл явцад залуучуудыг татан оролцуулах, тэдний нийгмийн оролцоог улам бүр хөхүүлэн дэмжих нь доорх ач холбогдолтой юм. Үүнд:

- Залуучуудад шинэлэг санаа, өөдрөг төсөөлөл, маш их эрч хүч байдаг, тэд өөрсдийн өнцгөөс асуудлыг арай өөрөөр харах магадлал өндөртэй юм .
- Монгол улсад залуучууд хүн амын томоохон хувийг эзэлдэг тул тэд нийгмийн ерөнхий хэрэгцээ шаардлагын илэрхийлэл болдог.
- Залуучууд бол улс орны ирээдүйг тодорхойлогчид, ирээдүйн удирдагчид юм. Иймд тэднийг зөв төлөвшүүлэх, хөгжүүлэхэд нийгмийн аливаа асуудалд татан оролцуулах нь чухал ач холбогдолтой юм.

## **СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

Сайн дурын үйл хэрэг нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тодорхойлсноор гурван үндсэн шинж чанартай байдаг: үйл ажиллагаа нь сайн дурын үндсэн дээр хийгдсэн байх, олон нийтийн сайн сайхны төлөө, мөнгөн шагнал нь гол хүчин зүйл биш байх гэжээ. Сайн дурын ажил хэмээх ойлголт нь нийгмийн идэвх гэсэн ойлголттой олон талаар давхцдаг. Харин нийгмийн идэвх нь нөлөөллийн ажил, аян зэрэг байдлаар явагддаг (Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны төлөв байдлын тайлан, 2015).

Залуучуудын нийгмийн идэвх оролцоо ямар байгаа, тэдний оролцоог байгууллагын удирдлага дэмждэг эсэхийг тодруулах, нийгэмд чиглэсэн компани ажлыг уриалж, түүнд залуучууд хэрхэн оролцож байгаад ажиглалт хийх зорилгоор судлаач миний бие Удирдлагын академийн бизнесийн удирдлагын өдрийн ангид суралцсан хэсэг залуучуудыг удирдаж 2017 оны 11 сарын 28 ны өдөр “УБ субботник” сайн дурын аянг санаачлан зохион байгуулсан.



“УБ Субботник” аянг зохион байгуулах болсон үндэслэл нь Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан “Хот тохижилт, цэвэрлэгээний талаар байгууллага, аж ахуй нэгж, иргэдээс дагаж мөрдөх журам”-д зааснаар байгууллагынхаа ойр орчмын 50 метр газрын цас мөсийг цэвэрлэх заалт төдийлөн хэрэгжихгүй байгаа, мөн цөөнгүй иргэд гудамжны хальтиргаанаас болж бэртэх, эрүүл мэндээрээ хохирч байгааг нийгмийн тулгамдсан асуудал гэж үзсэн юм. Ингээд энэхүү асуудлыг шийдвэрлэхэд өчүүхэн ч гэсэн хувь нэмэр оруулах зорилгоор “УБ Субботник” аяныг зохион байгуулсан.

Байгууллагынхаа ойр орчмын 50 метр газрын цас мөсийг цэвэрлэхийг уриалсан “УБ Субботник” сайн дурын аянд Монгол улсад бүртгэлтэй, таваас дээш жил тасралтгүй худалдаа үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлж байгаа арван Аж Ахуй Нэгж Байгууллага (ААНБ) оролцоно хэмээн зөвшөөрч, хамрагдсан. Эдгээр ААНБ-д 18-35 насны нийт 230 залуучууд ажилладаг гэсэн бүртгэл байсан. Эдгээр залуучууд “УБ Субботник”-т хэрхэн оролцсоныг ирцийн бүртгэлээр хянаж, тэдний идэвх оролцоог ажигласан. Мөн энэхүү аянд оролцсон 18-35 насны залуучуудаас өнгөрсөн нэг жилийн хугацаанд нийгэмд чиглэсэн сайн дурын ажилд оролцож байсан эсэх, оролцохдоо сайн дураар эсвэл албадлагаар оролцож байсныг илрүүлэхээр санал асуулга авсан.

Сайн дурын аянд оролцсон 10 байгууллагын хүний нөөцийн менежер, удирдлагыг “Shier-ийн оролцооны зам загвар”-ын багц асуулт бүхий санал асуулгад хамруулсан.

## ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Сайн дурын аян арга хэмжээнд 18-35 насны 230 залуучуудаас 111 нь оролцсон болохыг залуучуудын ирцийн бүртгэлээр тогтоосон. Нийгмийн ажилд оролцсон залуучуудын оролцоо 48.2 хувьтай байсан нь сайн дурын аянд оролцох байсан нийт 230 залуучуудаас ойролцоогоор хоёр хүн

тутмын нэг нь идэвхтэй оролцсон гэсэн дүгнэлтэд хүрсэн. “УБ Субботник” сайн дурын арга хэмжээнд оролцсон залуучуудын оролцоо болон талбайг цэвэрлэсэн гүйцэтгэлийн үнэлгээг хүснэгт 1-т үзүүлэв.

*Хүснэгт 1. “УБ субботник”-т хамрагдсан байгууллагуудын талаарх мэдээлэл*

№	Судалгаанд хамрагдсан ААНБ	Байгууллагад ажиллаж байгаа 18-35 насны залуучуудын нийт тоо	Сайн дурын арга хэмжээнд оролцсон залуучуудын оролцоо /залуучуудын тоо/	Цэвэрлэгээний гүйцэтгэлийн үнэлгээ 5-онц; 4-сайн; 3-дунд; 2- муу
1	Б 1	23	18	Сайн
2	Б 2	21	13	Дунд
3	Б 3	25	19	Дунд
4	Б 4	27	20	Сайн
5	Б 5	17	12	Сайн
6	Б 6	15	10	Сайн
7	Б 7	28	18	Дунд
8	Б 8	23	-	-
9	Б 9	32	-	-
10	Б 10	19	11	Сайн
		230	111	

*Жич: Байгууллагуудын нэрийг нууцлав.*

Сайн дурын аян арга хэмжээнд оролцсон байгууллагуудын гүйцэтгэл дунджаар 3.65 гэж үнэлэгдсэн бөгөөд харин хоёр байгууллагын залуучууд оролцоогүй юм.

Сайн дурын аянд оролцсон 18-35 насны залуучуудаас өнгөрсөн нэг жилийн хугацаанд нийгэмд чиглэсэн сайн дурын ажилд оролцож байсан эсэхийг санал асуулгын хуудсаар асуухад нийт судалгаанд хамрагдагсдын 47 хувь нь оролцож байсан гэж хариулжээ. Тэдний 55 хувь нь эрэгтэй, 45 хувь нь эмэгтэй байсан бөгөөд энэ нь хүйсийн төлөөлөл бараг ойролцоо тэнцүү байгааг харуулж байна. Нийгэмд чиглэсэн арга хэмжээнд оролцсон залуучуудын 66 хувь нь сайн дураараа, харин 34 хувь нь албан хүчээр оролцсон гэжээ.

Сайн дурын аянд оролцсон 10 байгууллагын хүний нөөцийн менежер, удирдлагаас “Shier-ийн оролцооны зам загвар”-ын багц асуултаар, тухайлбал: залуучуудын оролцоог дэмждэг эсэхийг, байгууллага залуучуудын оролцоог дэмжих зохион байгуулалт, нөхцөл боломжийг бий болгосон эсэхийг, байгууллагын бодлого хөтөлбөр, дотоод дүрэм журамд залуучуудын оролцоог дэмжих талаар тусгасан эсэхийг тодруулсан. Эхний асуултанд залуучуудын оролцоог дэмждэг гэж 100 хувь хариулсан. Залуучуудын оролцоонд дэмжлэг үзүүлэх зохион байгуулалт, нөхцөл боломжийг бий болгож чадсан “хангалттай” гэж 4 байгууллага, үлдсэн 6 байгууллага нь “дунд зэрэг” гэж хариулсан байна. Харин байгууллагын бодлого хөтөлбөр, дотоод дүрэм журамд залуучуудын оролцоог дэмжих талаар тусгасан эсэхийг асуухад 6 байгууллага нь “тийм”, 4 байгууллага нь “үгүй” гэж хариулжээ.

Нийгмийн оролцоонд мэдээлэл харилцааны технологи болох интернет, нийгмийн цахим сүлжээ, блог зэрэг харилцаа холбооны арга хэрэгслийг өргөн ашиглах болсноор дуу хоолойгоо хурдтайгаар олон хүмүүст хүргэх боломжтой болсон. Монголд 1996 оноос интернет нэвтэрсэнээс хойш, интернет болон үүрэн утасны ашиглалт орон даяар, түүний дотор хөдөө орон нутагт хурдацтай өргөжсөн. Интернет хэрэглэгчдийн тоо түргэн өсч, хүн амын 81 хувьтай тэнцэж байна. Тэдний 80 гаруй хувь нь Facebook-ээр холбогджээ. Энэ нь залуучуудад олон талын боломж нээсэн. Интернет хэрэглэгчдийн ихэнх нь залуучууд бөгөөд тэд интернетийг бие биетэйгээ холбогдох, нийгмийн үйл ажиллагаанд оролцоход ашиглаж байна. Олон залуучууд Twitter, Facebook, Блог зэрэг нийгмийн цахим сүлжээг мэдээллийн эрх сурвалж, нийгмийн хөдөлгөөн, үйл ажиллагааг дэмжих, ялангуяа дургүйцлээ илэрхийлэх хэрэгсэл болгон ашиглаж байна. Тухайлбал, Facebook-ээр залуучуудын 41 хувь нь санал бодлоо “байнга” илэрхийлдэг бол 42 хувь нь “зарим үед оролцдог”, 38.6 хувь нь “огт оролцдоггүй” гэсэн байна. (Залуучуудын улс төрийн оролцоо: 18-35 нас судалгааны тайлан, 2016).

Хүснэгт 2. Улсын хэмжээнд интернет хэрэглэгчдийн тоо

Интернет хэрэглэгчид	2018
Интернетийн байнгын хэрэглэгчид (мян.хүн)	2,745.6
Суурин интернет хэрэглэгчид (мян.хүн)	306.2
3G хэрэглэгч (мян.хүн)	2,439.4

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

“УБ субботник чэлленж” сайн дурын аяныг цахим сүлжээгээр уриалахад олон залуучууд дэмжиж байгаагаа илэрхийлэн сэтгэгдэл бичиж байсан. Энэхүү аяныг сонирхож үзсэн 41060 хүн, түүнээс сэтгэгдэл бичсэн 38, бусдад дамжуулж хуваалцсан 27, таалагдсан гэж лайк дарсан 83 залуучууд байсан. Харин цахим сүлжээгээр дэмжиж байсан залуучуудаас тухайн арга хэмжээнд оролцохоор ердөө тавхан залуучууд ирсэн нь зөвхөн нэг тохиолдол хэдий ч бодит амьдрал дээр залуучуудын нийгмийн оролцоо ямар байгааг харуулж байна (Хүснэгт3).



Хүснэгт 3. “УБ субботник” аяныг цахим сүлжээгээр урналахад, залуучууд хүлээн авч дэмжиж оролцсон байдал

Сонирхож үзсэн хүмүүсийн тоо	Дэмжсэн сэтгэгдэл	Бусадтай хуваалцсан байдал	Таалагдсан гэж лайк дарсан	Оролцохоор ирсэн залуучуудын тоо
41060	38	27	83	5

Залуучуудын нийгмийн оролцооны бас нэг хэлбэр бол улс төрийн оролцоо бөгөөд залуучуудын сонгуульд хэрхэн оролцож байгаагаар тэдний улс төрийн оролцооны идэвх ямар байгааг тодорхойлж болох юм. Конрад-Аденуаэр Сангийн захиалгаар хийгдсэн “Залуучуудын улс төрийн оролцоо: 18-35 нас судалгааны тайлан” (2016)–д Монгол улсын 3 аймаг, Улаанбаатар хотын 3 дүүргийн 18-35 насны нийт 1051 залуучуудыг түүвэрлэн судалгаанд хамруулжээ. Энэхүү судалгаанд оролцсон 4 залуу тутмын нэг буюу 25 хувь нь улс төрийг сонирхож байгаа бол, гурван залуу тутмын нэг нь буюу 29.5 хувь нь хааяа сонирхдог, 2 залуу тутмын нэг нь буюу 45.5 хувь нь улс төрийн сонирхолгүй гэсэн хандлага гарчээ. Мөн давхардсан тоогоор 67.9 хувь нь сонгуульд саналаа “байнга” өгдөг бол 77 хувь нь “зарим үед оролцдог”, 61.1 хувь нь “огт оролцдоггүй” гэсэн үр дүнг гаргасан байна. Залуучуудын улс төр сонирхож байгаа байдлыг хүйсээр харьцуулахад эрэгтэйчүүдийн 61,1 хувь нь, эмэгтэйчүүдийн 47,9 хувь нь ямар нэг байдлаар улс төрийг сонирхдог гэж хариулжээ (Залуучуудын улс төрийн оролцоо: 18-35 нас судалгааны тайлан, 2016).

Судалгаанд хамрагдсан байгууллагуудын удирдлага, менежер нар залуучуудыг дэмждэг гэсэн хэдий ч залуучуудын оролцоонд дэмжлэг үзүүлэх зохион байгуулалт, нөхцөл боломжийг бий болгох талаар дунд зэрэг харин бодлого хөтөлбөр, дотоод дүрэм журамд залуучуудын оролцоог дэмжиж тусгасан байдал хангалтгүй гэж дүгнэгдсэн нь залуучуудын шинэлэг санаа, эрч хүчийг хангалттай ашиглаж чадахгүй байгааг харуулж байна. Иймд төрийн болон бизнесийн байгууллагуудын удирдлага залуучуудтай илүү ойр дотно байж, үр дүнтэй харилцах арга барилд суралцах, бодлого хөтөлбөрүүд, дотоод дүрэм журмыг тэдний сонирхолд илүү нийцүүлэх, тэдний шинэлэг санаа, авьяас чадварыг үнэлж түншээ болгон хамтран ажиллах хэрэгтэй байна. Мөн залуучуудын сайн дурын ажилд оролцох хүсэл сонирхлыг өдөөх, тохирох хөшүүргээр дэмжих, урамшуулах, залуучуудын үйлдсэн сайн үйлсийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах замаар бусдад нөлөөлөх зэрэг арга хэмжээг авах нь зүйтэй юм.

Shier-ийн оролцооны замд тодорхойлсон залуучуудыг сонсдог байх, өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх, санаачилгаа хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлдэг байх, шийдвэр гаргах процессд залуучуудыг татан оролцуулдаг байх, эрх мэдэл хариуцлагыг хамтран хүлээдэг байх гэсэн зарчмуудыг хүлээн зөвшөөрч, байгууллагын дүрэм журамдаа тусгах нь залуучуудын нийгмийн оролцоог дэмжиж байгаа хамгийн чухал хэлбэр болно.

Залуучуудын нийгмийн хөгжилд илүү бүтээлч, үр нөлөөтэй оролцдог байдлыг нэмэгдүүлэх, тэдний хэрэгцээ шаардлагад мэдрэмжтэй ханддаг болохын тулд залуучуудын хүсэл эрмэлзэл, үнэт зүйлс хэрхэн бүрдэж, өөрчлөгдөж байгаа хандлагыг тогтмол судалдаг байх нь чухал юм. Залуучуудын нийгмийн оролцоогоор дамжуулан тэдний практик ур чадварыг хөгжүүлэх, ирээдүйн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, багаар ажиллах чадвар суулгах зорилгоор залуучуудын нийгмийн оролцоог дэмжсэн сургалтын хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургалтанд оруулж болох юм.

Залуучуудын нийгмийн оролцоо нь багаар ажиллах чадвар гэсэн ойлголттой салшгүй холбоотой юм. Хүн аливаа зүйлийг өөрөө хийж үзэх, өөрийн биеэр оролцсоны үр дүнд суралцан хөгждөг. Нийгмийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдэхэд залуучууд өөрсдийн биеэр оролцож, нэг зорилготой нэгдмэл баг болж ажиллаж чадвал илүү үр дүнд хүрэх магадлалтай юм.

Залуучуудын төр засагт итгэх итгэл буурч байгаа нь засаглалыг сайжруулах, улс төрчдийг ёс зүйтэй байхыг шаардаж буй дохио хэмээн ойлгож, бодлого боловсруулагчид, төр засгийн түшээдүүд, улс төрчид залуучуудыг хөгжлийн хүч гэдэг утгаар нь авч үзэн, тэдний нийгмийн болон улс төрийн оролцоог дэмжих, итгэлийг нь эргүүлэн олж авахын тулд сайн үлгэр дууриалал үзүүлэх хэрэгтэй болжээ.

## ДҮГНЭЛТ

Судалгаанд хамрагдсан залуучуудын бараг хоёр хүний нэг нь олон нийтийн үйл ажиллагаанд сайн дураараа оролцож байсан, сонирхолтой байдаг гэсэн хэдий ч залуучуудын нэгдсэн зохион байгуулалт, санал санаачлага дутагдаж байгаа нь харагдаж байсан.

“УБ Субботник” аянд оролцсон зарим байгууллагуудын удирдлагууд залуучуудын оролцоог дэмжихийг хүсдэг хэдий ч өөрийн байгууллагын бодлого хөтөлбөртөө залуучуудыг дэмжих талаар тусгаагүй байсан. Иймд байгууллагын удирдлага залуучуудын санаачлага, нийгмийн идэвх оролцоог хөхүүлэн дэмжих талаар бодлого хөтөлбөртөө тусгаж, залуучуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ түүнийг харгалзан үздэг байж болох юм.

Судалгааны үр дүнгээс харахад залуучуудын нийгмийн оролцоонд хүйсийн нөлөө бага, эрэгтэй эмэгтэйчүүд бараг тэнцүү оролцоотой байсан бөгөөд өнгөрсөн нэг жилийн хугацаанд нийгмийн төлөөх арга хэмжээнд таван оролцогч тутмын гурав нь сайн дураар оролцсон бол таван оролцогч тутмын хоёр нь албадлагаар оролцсон байна.

Интернет нь нийгмийн оролцооны сүлжээ бий болгох, залуучуудын оролцоог дайчлах, мэдээлэл солилцох гол хэрэгсэл түргэн хугацаанд болж чаджээ. Интернетийн хүртээмжийг, ялангуяа хөдөө орон нутагт өргөжүүлэх, сайн дурын ажлыг санаачлагч залуучуудын үлгэр дуурайлыг түгээх нь залуу үеийг нийгмийн өөрчлөлтийн үр нөлөөтэй хөдөлгөгч хүч болгож төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Цахим сүлжээний орчинд залуучууд сайн дурын аянг дэмжиж байгаагаа илэрхийлж, цааш дамжуулан хуваалцаж байсан хэдий ч тухайн нийгмийн арга хэмжээнд оролцохоор ирсэн залуучуудын тоо цөөн байсан.

Залуучууд ТББ-аас зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог хэдий ч өөрсдөө санаачлан зохион байгуулах оролцоо сул байна. Нийгэмд тустай сайн дурын ажлыг санаачилдаг залуучуудыг магтан сайшааж, тэднийг бахархах сэтгэгдлийг залуусын дунд төрүүлэх хэрэгцээ байна.

## **НОМ ЗҮЙ**

Монгол хэлээр:

[1] “XXI зуун-Монголын залуучууд” суурь судалгаа (2011). Монголын залуучуудын холбоо, Улаанбаатар

[2] Үндэсний статистикийн хорооны мэдээлэл (2018). Улаанбаатар

[3] Монгол улсын хүний хөгжлийн илтгэл (2016). НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Улаанбаатар

[4] Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны төлөв байдлын тайлан (2015). НҮБ

[5] Залуучуудын улс төрийн оролцоо: 18-35 нас судалгааны тайлан (2016). Удирдлагын Академи, Улаанбаатар

Гадаад хэлээр:

[6] The state of youth policy in 2014, <http://www.youthpolicy.org/blog/2014/05/state-of-youth-policy2014/>

[7] De Backer, Kurt and Jans, Marc (2002) Youth and Social Participation: Elements for a Practical Theory. Brussels: Flemish Youth Council

[8] Children's Participation: From Tokenism to Citizenship (1992)

[9] Shier, H (2001) Pathways to participation: Openings, Opportunities, Obligations, Young people and society.

[10] Commonwealth Youth Programme Participation Toolkits (2006), UNICEF Hart's "Ladder of Participation" (1992). .

[11] <http://www.myd.govt.nz/documents/engagement/harts-ladder.pdf>